

ШИНЭ НОМЫН ТАНИЛЦУУЛГА

ХҮҮХДИЙН МЭСЗАСЛЫН ӨВЧИН

- 1. Номын нэр:** ХҮҮХДИЙН МЭСЗАСЛЫН ӨВЧИН
/Нэмэлт хийж хянан засварласан хоёр дахь хэвлэл/
- 2. Зохиогч:** Дашжамцын АВИРМЭД
- 3. Хянаннягталсан:** Магсарын ТҮМЭННАСАН
- 4. Хэвлэсэн он:** 2016 он
- 5. Хэвлэлийн хуудас:** 102.5 х.х
- 6. Хэвлэсэн тоо:** 200

Номын тухай

Хүүхдийн мэсзаслын өвчин хэмээх энэхүү нэмэлт хийж, хянан засварласан хоёр дахь хэвлэл-үндсэн долоон бүлэг, дэд бүлгүүдтэй ба хавсралт нэг бүлэгтэй, нийт 59 хүснэгт, 202 зурагтай бөгөөд 461 хэвлэл ашигласан болно.

Эл номонд орсон гаж хөгжил ба өвчний тодорхойлолт, шалтгаан, эмгэгжам, эмнэлзүй, оношилгоо, эмчилгээ, тавилан, урьдчилан сэргийлэлт гэсэн дэс дарааллаар, орчин цагийн ойлголт, мэдээллийн түвшинд бичихийг хэчээсэн болно.

Эмнэлгийн нэр томъёо хараахан нэгэн мөр болоогүй байгааг бодолцон зарим өвчний ба хагалгааны нэрийг орос, англи-аар орууллаа.

Хүүхдийн мэсзаслын өвчин хэмээх эл номыг мэсзасал, мэдээгүйжүүлэг-эрчимт эмчилгээ-сэхээн амьдруулахуйн, дүрс оношилгооны, сэргээн засахын, өрхийн болон резиденс эмч нар, анагаах ухааны их дээд сургууль, коллежийн оюутны мэргэжил, мэдлэгт нэмэр болгохыг үндсэн зорилго болгов.

Баатад овогт Дашжамцын АВИРМЭД

Мэргэжил нэгт нөхөддөө

Манай оронд мэсзаслын олон төрөл, чиглэл хөгжиж байгаагийн нэг нь хүүхдийн мэсзаслын алба юм. Хүүхдэд тохиолддог төрөлхийн (улаанхоолойн төрөлхийн битүүрэл, өрцний ивэрхий, хэвлийн цоорхой гэх мэт) ба хожмын өвчнийг эрт оношилж, хөгжсөн орны эмчилгээний загвар-жишигт хүргэх, хүүхэд бүрийг эрүүл саруул өсгөхөд хүүхдийн анагаах, хүүхдийн мэсзаслын алба, эмч мэргэжилтний нягт нямбай хамтын үйл ажиллагааны үүрэг, зорилго нь шийдвэрлэх ач холбогдолтой.

Иймээс хүүхдийн анагаах, хүүхдийн мэсзаслыг сургалт-эрдэм шинжилгээ-практикийн нэгдмэл нэг түвшинд авч үзэн хөгжүүлэх нь чухал хэвээр байгаа болно.

Хүүхдийн эрхтэн тогтолцоо бүтэц, үйл ажиллагааны хувьд онцлогтой хэдий ч том хүн өвддөг бүх өвчнөөр нэгэн адил өвдөхийн зэрэгцээ мэсзаслаар эмнэдэг гаж хөгжилтэй төрөх нь, жилээс жилд олширч байна. Иймээс нярай ба бага насны хүүхдэд үзүүлэх мэсзаслын тусламжийн чанарт онцгой анхаарч (нярай хүүхдийг зөөж тээвэрлэлгүй өрөө байранд нь хагалгаа хийдэг болох), улам сайжруулах шаардлага тулгарч байна.

Манай эмч нар хөгжсөн орнуудад туршлага судалж, орчин цагт хэрэглэж буй шинэ шинэ арга барилаас сурч, хүүхдийн мэсзаслын шинжлэх ухаанд дорвитой хувь нэмэр оруулан хөгжүүлж байна. Чингэснээр манай мэсзасалчдын мэдлэг, боловсрол, мэргэжлийн ур чадвар, урлахуйн ухаан нь, эх орны болон гадаадын эрдэмтэд, профессорууд, судлаачдын амжилтын зэрэг зиндаанд зарим талаар ойртож, мөн зарим талдаа хүрээд байгаа болно.



Миний бие, жаран жил амжилттай хөгжиж буй монголын хүүхдийн мэсзаслын нэр хүндтэй хийгээд хариуцлагатай албанд үе үеийн эмч мэргэжилтэн нарын хамт тавь шахам жил ажиллахын сацуу мэргэжлийн цөөнгүй номыг, нөхдийн хамт болон бие даан бичиж, нийтийн хүртээл болгосноос хойш багагүй хугацаа улиран одсон байна.

Хүүхдийн мэсзаслын хамт олны ба бусад орны хүүхдийн мэсзасалчдын ололт, амжилт, хүрсэн түвшин хийгээд өөрийн туршлага, уншиж мэдсэн, үзэж харсан, сонссон зэрэгтээ тулгуурлан 2010 онд, "Хүүхдийн мэсзаслын өвчин" хэмээх ном бичиж, гаргасан авч, өдгөө олдохгүй болоод удаж байгаа болно. Иймд, уг номондоо нэмэлт хийн хянан засварлаж, нийтийн хүртээл дахин болгож буй маань энэ болой.

Гадаад улсын хэлээр туурвисан, олон төрлийн ном уншдаг, мөн хэлээр бичдэг болсон энэ цаг дор, эрхэм Таны хайрлаж явдаг, хамгаас үнэтэй цаг завьг тань бага үрэхийн үүднээс, монгол нэртомъёоны хувьд жигдрээгүй буй зарим нэгэн өвчний нэрийг орос, англи хэлээр хавсаргасан болно.

Энэхүү номонд монголын хүүхдийн мэсзаслын түүхэн хөгжил, мэсзаслын өвчний оношилгоо эмчилгээ, мэдээгүйжүүлэг, эрчимт эмчилгээ, сэхээн амьдруулахуйн онцлог, хагалгааны өмнө ба дараа үеийн сэргээн засах эмчилгээний арга барилаас аль болохоор ойлгомжтой тусгахын мэрийсэн болно.

Ном бүтээхэд оролцож, тусалсан Монгол Улсын Төрийн шагналт, доктор, клиникийн профессор М. Түмэннасан, Монгол Улсын Төрийн шагналт, клиникийн профессор Д. Дамдин., Монгол Улсын Төрийн шагналт клиникийн профессор, зөвлөх эмч Д. Ганчимэг, анагаах ухааны доктор, дэд профессор А. Балжинням., эмч Д. Отгонгэрэл., С. Бурмаа., Б. Одгэрэл., А. Ганчимэг., Ч. Дулаамрагчаа, М. Ариунтунгалаг., С. Сэргэлэн., Ц. Цогзолмаа., Ч. Баттулга., Ч. Гантулга болон зээ хүү А. Энхбаяр нартаа баярлаж, талархаж байгаагаа илэрхийлэхийн зэрэгцээ туурвин бүтээх их үйлстээ амжилттай байхыг ерөөе.

Энэхүү номонд дутуу дулимаг, ойлгомж тааруу, зарим сэдэв нь товч, мөн нуршсан, давхардсан санаа, оновчтой биш нэртомъёо хэрэглэсэн гэх мэт алдаа мадаг байх учир

мэргэжил нэгт, мэргэшихийг зорьж буй эрхэм Танаас хүлцэл өчихийн ялдам санал, хүсэлт, шүүмжээ ЭХЭМҮТ-ийн мэсзасалч, зохиогч надад ирүүлж, миний ажил үйлст туслана гэдэгт гүнээ итгэнэм.

*Монгол Улсын Төрийн шагналт,
клиникийн профессор
Баатад овогт Дашжамцын АВИРМЭД*